

ОРЧУУЛГА БА АЛШАА ЭЗНЭЭ АМАН АЯЛГУУНЫ ОНЦЛОГ

Б.Яруу⁹³

1. Удиртгал

Дэлхийн орчуулгын өдрийг тохиолдуулж би орчуулгатай холбоотой хэдэн юм хэлмээр байна. Би бол багаасаа монгол сургуульд суусан, Өвөр Монголын монгол хүүхэд билээ. Гэтэл орчин тойрон, уулзаж учирч байгаа хүмүүс маань олонх нь хятад хүн болохоор заримдаа ямар нэг зүйлийг хятадаар унших нь надад илүү ойлгомжтой мэт бодогддог. Тэгээд Монголд ирсний дараа хичээлийн даалгаварт Галидасын “Үүлэн зардас” бүтээлийг унших шаардлагатай болов. Эхлээд би хятадаар уншсан. Дараа нь Бямбын Ринчен гуайн монгол орчуулгыг нь уншихад үнэхээр миний сэтгэлд хүрсэн гэдгийг юу нуух билээ. Сайн орчуулга гэдэг нь нэг нэг үсгээр махчилж орчуулах биш, харин тухайн үндэстний хэлэнд ойрхон, ойлгомжтой орчуулж чаддаг болохоор уншигчийн сэтгэлд хүрдэг юм байна гэдгийг мэдлээ.

Алшаа аман аялгуу бол Өвөр Монгол аялгууны баруун захын аман аялгуу болно. Алшаачууд бол алс баруунтай Шинжаан, Хөхнуураас урьд хожид нүүдэллэж ирсэн ойрад монголчууд гэдэг. Тийм болохоор Алшаа аман аялгуу ойрад аялгуутай нэлээд төстэй болж, харин Өвөр Монголын бусад аман аялгуунаас ялгарах онцлог нэлээд арвин байдаг.

2. Алшаа аймгийн тухай товч танилцуулга

Алшаа аймаг бол БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны хамгийн баруун захын аймаг бөгөөд 267.574 км² талбайтай. Хойд хэсгээрээ Монгол Улсын Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай аймагтай хиллэдэг. Өвөр Монголд хамгийн том засаг захиргааны нэгж боловч хамгийн цөөн хүн амтай аймаг юм. 2018 оны бүртгэлд үндэслэвэл, Алшаа аймаг нийт 250,000 хүн амтай. Үүнд Хятад, Монгол, Манж, Төвөд, Хотон, Монгор буюу Цагаан монгол зэрэг үндэстэн багтана. Халх, торгууд, буриад, барга зэрэг ястнууд оршин суудаг. Үүний дунд зөвхөн 22.74% нь Монгол үндэстэн билээ.

Алшаа аймаг нь Алшаа зүүн хошуу, Алшаа баруун хошуу, Эзнээ хошуу хэмээх гурван хошуутай. Алшаа зүүн, баруун хошуунд хошууд ястан, Эзнээ хошуунд торгууд ястан гол цөм нь болдог.

⁹³ МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбар

3. Алшаа гэдэг үгийн гарлын тухай

Алшаа гэдэг үгийн гарлын тухай хэд хэдэн зүйлийн тайлбар байдаг билээ. Алшааг хятад хэлний Хө Лань Шань (贺兰山) гэдэг уулын нэрээс гаралтай гэж олонх эрдэмтэд үздэг. Хө Лань Шань-г монголчууд Алшаа уул буюу Хулан уул гэдэг.

4. Алшаачуудын гарал үүсэл, түүхийн тухай

Холбогдол бүхий материалд үндэслэвэл, Алшаа аймагт суурьшин амьдарч байгаа монголчуудын зонхилох хэсэг нь 300 гаруй жилийн өмнө Гэгэн гүүш хаан Төрбайхын хойч үе болох Эрх жононгийн Алшаад дайчлан дагуулж ирсэн хэсэг бүлэг хошууд ба өөлд ястны хойч үе болно. Арваннайм дугаар зууны эхээр Манж Чингийн төрийг дагасан хэсэг бүлэг торгуудчууд Цэвээнравдангаас зугтаан зайлахын төлөө бас Эзнээ голын дунд ба доод урсгал дагуу суурьшин амьдрах болжээ. Одоогийн Эзнээ хошууны торгуудчууд бол тэдний хойч үе болно.

Бас зарим хүмүүс Алшаачууд бол 300 гаруй жилийн өмнө алс баруунтай Шиньжян, Хөхнуураас урьд хожид нүүдэллэж ирсэн ойрад монголчууд гэдэг.

5. Алшаа аман аялгуу буюу Алшаа эзнээ аман аялгуу

Алшаа аман аялгуугаар ярилцагчид одоогийн Алшаа зүүн, баруун, эзнээ хошуугаар нутаглан сууж байна. Аялгууны газарзүйн байршлаар Алшаа аман аялгууг бас Алшаа эзнээ аман аялгуу гэж нэрлэдэг. Алшаа эзнээ аман аялгуу бол монол хэлний нутгийн аялгууны доторх нэлээд өвөрмөц онцлогтой аман аялгууны нэг болох юм. Өвөр Монгол аялгууны онцлог шинж, ойрад аялгууны онцлог шинжийг зэрэг хадгалсан болохоор зарим эрдэмтэн Алшаа эзнээ аман аялгууг бас Өвөр монол аялгуу ба ойрад аялгууны завсрын шинжтэй аман аялгуу гэж үзсэн байдаг.

6. Алшаа эзнээ аман аялгууны авиазүй, үгийн сангийн онцлог

Авиазүйн гол онцлог

Эгшиг авианы талаар:

(1) Алшаа эзнээ аман аялгуу а, е, і, э, в, ө, у, э гэх найман богино эгшиг авиалбартай. е эгшигийн талаар Алшаа эзнээ аман аялгуу өвөрмөц онцлогтой. Дуудлага нь ойрад аялгууны е -тэй адилавартай байж, голдуу үгийн эхэн ба дунд тохиолдоно. ек--эх егке:---эрхий гэх мэт.

(2) æ эгшиг бол бичгийн хэлний хоёр, гуравдугаар үеийн і эгшигийн нөлөөгөөр үгийн эхний үеийн а эгшиг урагшилсны үр дүнд бий болжээ. Дуудлага нь ойрад аялгууны æ -тай адил, үгийн эхний үед тохиолддог. Жишээ : хæг -харь тæмиг - тамир гэх мэт.

Гийгүүлэгч авианы талаар:

Алшаа эзнээ аман аялгууны гийгүүлэгчийн авиалагдах байдал нь бичгийн хэл буюу бусад аялгуу, аман аялгууны гийгүүлэгчтэй үндсэндээ таарч байдаг.

Харин g, k, ts, dz дөрвөн гийгүүлэгчийн талаар онцлогтой зүйл байдаг .

⊖ Алшаа эзнээ аман аялгуунд монгол хэлний эхэнд ордог х гийгүүлэгчийг k-р авиалдаг үзэгдэл тодорхой оршдог. Голдуу эм үг буюу хөндий үгэнд тохиолддог. Заримдаа бас эр үгийн i эгшгийн өмнөх х гийгүүлэгчтэй тохиролцоно.

kel--хэл taka: -- тахиа ʃik--чих гэх мэт.

⊖ Монгол бичгийн хэлний ʃ гийгүүлэгч нь Алшаа эзнээ аман аялгуунд ʃ, ts болон салбарлажээ. Өвөр Монголын баримжаа авианд цөм ʃ-р авиалдаг бол, Алшаа эзнээ аман аялгуун дахь ʃ гийгүүлэгчийн авиалагдах байдал нь ойрад аялгуу, халх аман аялгуутай ижил байна. tsas -- цас ʃulu: --- чулуу гэх мэт.

⊗ Монгол бичгийн хэлний dz гийгүүлэгч нь Алшаа эзнээ аман аялгуунд мөн хоёр салбарлаж dz болон dz болжээ. Энэ нь ойрад аялгууны z гийгүүлэгчтэй их төлөв адил байж, Өвөр Монголын авга, сөнөд болон халх аялгуутай ч адилхан байна. Жишээ нь: dzɔɔ:--жолоо, dzɔɔ---зол гэх мэт.

④ Үүнээс гадна, Алшаа эзнээ аман аялгуунд “ G,γ ” хоёр гийгүүлэгчийг тодорхой ялган авиалдаг бөгөөд тус хоёр гийгүүлэгч нь үгийн эцэст утга ялгах үйлдэлтэй байдаг. Энэ нь кирил бичиг дэх хэлний “ г ” ба хоолойн “ г ” гэдэгтэй төстэй байна. Жишээлбэл:

Gar-гар arγal- аргал

baG - баг baγ- бага гэх мэт.

Үгийн сангийн онцлог

1. Алшаа эзнээ аман аялгуу нь бусад аман аялгуутай харьцуулбал өвөрмөц үгс харьцангуй олон байдаг.

Алшаачууд

⊖ толь гэдэг үгийг нүүрийн гэр гэж

⊖ хөөрхөн гэдэг үгийг барамхан гэж

⊗ алиа гэдэг утгатай үгийг елдэн гэдэг.

④ Үүний дунд бас ондоо утгат үг байдаг. Өвөр Монгол даяар нүдэн шил гэхэд, Монгол Улсад нүдний шил гэхэд, Алшаад саравч гэдэг.

2. Эртний зохиол, сурвалж бичигт илэрдэг зарим үгс Алшаа нутгийн монголчуудын дунд одоо болтол уламжлагдан хэрэглэгдсээр ирсэн жишээ олон байна. Жишээлбэл:

⊖ үрүүн — “ Монголын увш хун тайжийн тууж” гэх номд энэ үг өглөө гэсэн утгаар илэрсэн бол Алшаад мөн адил утгаар хэрэглэгдсээр эдүгээ хүрсэн билээ.

⊖ дэлтэр — дэлтрийг “ жангар ” номд эмээлийн хамгийн доор нь тохдог эсгийг зааж байсан бол Алшаачууд мөн эмээл тохмын доорх эсгийг дэлтэр гэж нэрлээд он уджээ.

3.Ер нь бурхны шашин Алшаа нутагт дэлгэрээд 300 гаруй жилийн түүхтэй болжээ. Яг ийм учраас Алшаа аман аялгуунд бас төвөд хэлнээс зээлсэн үг, төвөд гаралтай үг олон байдаг. Жишээлбэл:

Зэд тавих: түгээл өгөх

диграа: орос зүү

гүнцэг: лам нарын үдийн хоолны хүндэтгэл,

Цав: лам хуврагийн зоог зэрэг үгийг нь Алшаачууд өдөр тутмын амьдралдаа “та минь гүнцгээ барих юм уу?”, “Цаваа барих цаг болжээ” гэж шилжсэн утгаар нь хэрэглэдэг билээ.

4.Алшаа монголчууд нь оршин сууж байгаа орчин тойронд хятад үндэстний нөлөөнд автсанаас Алшаа аман аялгуунд бас хятад хэлнээс зээлсэн үг олон болсон байдаг. Үүнийг хотод амьдардаг монголчуудын ярианаас илүү мэдэж болно. Жишээ нь:

Пэнз (盆子) панз (盘子) ан бан (案板) хэмээн өдөр тутмын амьдралын аар саар зүйлүүдээ шууд хятадаар ярьдаг онцлогтой.

7. Дүгнэлт

Орон нутгийн онцлог шинжийг бүрэн хадгалсан ийм сайхан нутгийн аялгуугаа хамгаалж, өвлөж, хөгжүүлэх нь монгол хүн нэг бүрийн дархан үүрэг билээ. Энд Алшаа нутгийн малчин зохиолч Бармадын Улаанхүүг дурдах ёстой. Энэ хүн бол нутгийн аялгуугаараа зохиол бүтээлээ туурвидаг онцлогтой. Нэг талаар энэ нь мөн нутгийн аялгуугаа хамгаалж хөгжүүлж байгаа явдал гэж би боддог. Мэдээллийн зууны өрсөлдөөний дунд Монгол хэл, нутгийн аялгуугаа хэвээр хадгалан байлгаж гэвэл орчуулгын ажилтай холбож, улам олон хүмүүст Монгол хэл, нутгийн аялгуугаа ойлгуулах нь чухал болов уу гэж би боддог юм.

Ном зүй

1.“Монгол хэлний нутгийн аялгууны шинжлэл”---М.Баатар. Б.Сод

2.“Алшаа аман аялгууны судлал”---Н.Гэрэлт